

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

Б.Цэнгэлхам¹

О.Нямтайван²

АПЕК-ийн гишүүнчлэлийн хориг

АПЕК нь одоогийн байдлаар нийт 21 гишүүн эдийн засагтай. Анх 1989 онд 12 гишүүн (Австрали, АНУ, Бруней, Индонез, Малайз, Өмнөд Солонгос, Сингапур, Тайланд, Филиппин, Япон, Шинэ Зеланд) нэгдэн АПЕК гэх эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явцын суурийг тавьсан. Улмаар АПЕК хүрээгээ тэлж 1991 онд БНХАУ, Тайвань, Хонгконг, 1993 онд Мексик, Папау Шинэ Гвиней, 1994 онд Чили, 1997 онд Вьетнам, ОХУ, Перу тус тус эгнээнд нь нэгдсэн.

АПЕК-т элсэн буй улс орнуудыг гишүүн орон гэхээс илүү гишүүн эдийн засаг хэмээн тодорхойлохоор 1990 оны 7-р сард болсон АПЕК-ийн сайд нарын уулзалтаар шийдвэрлэсэн. Энэ нь АПЕК-ийн байгууллага гэхээс илүү тодорхой зорилт дээр нэгдсэн бүсийн эдийн засгуудын хамтын ажиллагааны интеграцийн үйл явц гэдэгтэй холбоотой.

АПЕК-ийг анх байгуулж байх үедээ удирдагчид нь гишүүнчлэлийг цаашдаа нээлттэй байлгана гэж тохиролцож байсан боловч 1989 оны 11-р сард болсон АПЕК-ийн сайд нарын I хурлын үеэр шинэ гишүүн элсүүлэх шалгуурыг баталж гаргаагүй нь дээрх асуудлыг эргэлзээтэй, ээдрээтэй болгосон.

1. ОУХХ-ийн Бүс нутаг, олон улсын байгууллагын салбарын ЭША

2. МУИС-ийн ОУХНУС-ийн оюутан

1990 оны 7-р сард болсон АПЕК-ийн сайд нарын II хурлаар БНХАУ, Тайвань, Хонгконгийг гишүүнээр элсүүлэх асуудлыг нухацтай авч хэлэлцсэн. Энэ нь АПЕК-ийн түүхэн дэх гишүүн элсүүлэх гэсэн хүчин чармайлт гаргасан ганц тохиолдол байв. “Турван Хятад” хэмээн нэрлэгдэх БНХАУ, Тайвань, Хонгконг 1991 онд АПЕК-т нэгдсэн.

1991 оны Сөүлийн тунхаглалд АПЕК гишүүн элсүүлэх анхны багц шалгуураа батлан гаргасан байна.³ Уг шалгуураар:

- Ази-Номхон далайн бүсэд эдийн засгийн хүчтэй харилцаа холбоотой байх,
- Ард иргэдийн сайн сайхны төлөө бүсийн өсөлт хөгжлийг хадгалах, чингэснээр дэлхийн эдийн засгийн өсөлт хөгжилтөнд хувь нэмрээ оруулах,
- Эдийн засгийн өсөж буй харилцан хамаарлаас үүдэн дэлхийн хэмжээний болон бүс нутгийн хэмжээний амжилтыг дээшлүүлэх,
- Ази, номхон далайн орнуудын болон бусад орнуудын ашиг сонирхлын үүднээс олон талт нээлттэй худалдааны тогтолцоог хөгжүүлж, бэхжүүлэх,
- Зах зээлийн эдийн засгийн системтэй байх,
- Оролцогчдын хоорондох бараа, үйлчилгээ, худалдаа, хөрөнгө оруулалтын саад тотгорыг багасгах,
- Гишүүн элсүүлэх шийдвэр нь бүх гишүүдийн зөвшилцлийн үндсэнд хийгдэх.

1992 оны 9 сард болсон сайд нарын IV уулзалтаар шинэ гишүүн элсүүлэх шалгуурыг нарийвчлан боловсруулсан.

Одоогийн байдлаар 3 удаа хориг тогтоогоод байна.

- АПЕК-ийн анхны гишүүнчлэлийн хориг (1993-1997)
- АПЕК-ийн гишүүнчлэлийн II хориг (1997-2007)
- АПЕК-ийн гишүүнчлэлийн III хориг (2007-2010)

1993 оны сүүлээр Ерөнхийлөгч Билл Клинтоны даргалсан Блейк Айландын хурлаар АПЕК зорилгоо илүү нарийвчилж, жил бүр тогтмол

3. <http://www.parliament.mn/news/open/categories/30/pages/3438>

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

удирдагчдын хурал хийх, нээлттэй байр суурьтай байх болсноор олон улсын анхаарлыг татан, АПЕК-т элсэхийг хүсэгчдийн тоо нэмэгдсэн. Гэвч 1993 оны 11-р сарын сайд нарын хурлаар АПЕК-т шинэ гишүүн элсүүлэх асуудлыг 3 жилээр хойшлуулж анхны гишүүнчлэлийн хориг (moratorium) тогтоосон байна. Ингэж гишүүнчлэлдээ хязгаарлалт тавьснаар АПЕК-ийн ажлын хэсгүүд болон бусад форумуудтай холбоотой оролцооны асуудлыг шийдвэрлэхийн тулд 1995 онд гишүүн бус орнуудын оролцооны статусыг бий болгож анхны багц шалгуурыг баталсан байна. Оролцооны статус нь гишүүчлэлээс салангид ойлголт юм.

1996 онд буюу анхны гишүүнчлэлийн хориг дуусах үед ОХУ, Энэтхэг, Монгол Улс, Перу, Вьетнам, Эквадор, Колумб, Лаос, Панам зэрэг орнууд нэр дэвшигчдийг тэргүүлж байсан ба 1991 оны гишүүн элсүүлэх шалгуурыг баримталж байв. Шалгуурын нэг хэсэг болох гишүүдийн зөвшилцлийн шалгуур асуулт дагуулж, АНУ, Австрали зэрэг улсууд шинээр гишүүн элсүүлэхийг эсэргүүцэж байв.⁴ Учир нь, гишүүн нэмснээр тэр үеийн эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлэн хөгжүүлэх боломжгүй болно хэмээн үзэж байв. АПЕК-ийн тухайн үеийн ажлын хэсгийн дарга Фред Бергстен Европын Холбооны туршлага болох “Эхлээд гүнзгийрүүл дараа нь тэл” гэсэн бодлогыг санах хэрэгтэй гэсэн байр суурьтай байв. Тайландын ГХЯ-ны сайд 2000 онд “Гишүүнчлэлийн байнгын өргөжилт нь АПЕК-ийн дэвшилтийг хязгаарлаж болох юм” гэсэн утгатай үг хэлсэн байна. Харин Малайз улс эсрэг байр суурьтай байв. Малайз АПЕК-ийн гишүүнчлэл тус байгууллагын зорилгыг дэмжихийг хүсч байгаа бүх эдийн засгуудад нээлттэй гэж үзэж байв. Үүний зэрэгцээ зарим улс орнууд гишүүнчлэлийн асуудлыг өөрийн ашиг сонирхолын үүднээс харж, дэмжиж байв. Тухайлбал: Япон улсын Вьетнам дахь ашиг сонирхол, Перугийн Япон гаралтай Ерөнхийлөгч нь үүнд нөлөөлсөн байх магадлалтай гэж судлаачид үздэг.

1997 онд Ванкуверт болсон АПЕК-ийн удирдагчдын хурлаар шинэ гишүүн элсүүлэх шийдвэрийг голчлон гишүүдийн зөвшилцлийн үндсэн дээр ОХУ, Перу, Вьетнам улсуудыг гишүүнээр элсүүлэх шийдвэр гаргасан. Үүнтэй зэрэгцэн АПЕК гишүүнчлэлийн шинэ багц шалгуураа тогтоосон нь одоог хүртэл мөрдөгдөж байна.

4. http://www.mfa.gov.mn/index.php?option=com_content&view=article

Азийн эдийн засгийн хямралын эсрэг АПЕК дорвитой арга хэмжээ авч чадаагүй нь АПЕК-ийн нэр хүндийг унагаж, гишүүнчлэлийн асуудлыг зогсонги байдалд оруулсан.

1997 онд тавьсан АПЕК-ийн 10 жилийн хугацаатай 2 дахь гишүүнчлэлийн хориг тавьсан нь өөрийн ажлын хөтөлбөрөө эргэн харах, баталгаажуулах цаг хугацааг АПЕК-т олгоод зогсохгүй улс орнуудын сонирхолыг ахин татах бололцоог олгосон.

Одоог хүртэл хориг цуцлагдаагүй бөгөөд гишүүнчлэлийн талаарх яриа хэлэлцээр идэвхитэй бус байна.

Монгол Улс АПЕК-д элсэх шаардлага

Манай улс АПЕК-ийн зорилго, зарчмыг дэмждэг бөгөөд АПЕК-тай хамтран ажиллах, улмаар гишүүнээр элсэх сонирхолтой байгаагаа олон жилийн турш янз бүрийн түвшинд илэрхийлсээр ирсэн. Албан ёсны хүсэлтээ 1993 онд анх гаргасан боловч 1997 оноос эхлэн 10 жилийн хугацаанд шинээр гишүүн элсүүлэхгүй байх хориг тавьсаны улмаас хойшлогдож ирэв. Улмаар 2007 онд АПЕК-т элсэхээр Австрали, АНУ, Канад, Япон, Сингапур зэрэг нөлөө бүхий гишүүн эдийн засгуудтай ойртон ажилласан боловч АПЕК-ийн дээд түвшний XV хурлаас АПЕК-т шинээр гишүүн элсүүлэх асуудлыг 2010 он хүртэл 3 жилийн хугацаагаар дахин хойшлуулах шийдвэр гаргав. Ингээд 2010 онд гишүүнчлэлийн хориг цуцлагдсаны дараа элсэхээр гишүүн эдийн засгуудын дэмжлэгийг авах үүднээс манайд ирсэн болон Азийн орнуудад айлчлах манай төлөөлөгчдийн ажлын удирдамж, ярианы сэдэвт энэ асуудлыг байнга тусган ажиллаж ирсэн. Гэвч 2010 оны 11-р сард Японы Ёкохама хотноо болсон АПЕК-ийн дээд түвшний уулзалтаар удирдагчид АПЕК-т шинээр гишүүн элсүүлэх асуудлыг дараа авч хэлэлцэхээр хойшлуулав. Уулзалтын төгсгөлийн баримт бичигт “Өнөөгийн гишүүн эдийн засгуудын харилцан адилгүй байдлаас шалтгаан тэдгээрийн хөгжлийн түвшинг ойртуулах, АПЕК-ийн хамтын нийгэмлэгийн үзэл санааг бэхжүүлэхэд эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Бид эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг чадавхийг бэхжүүлэх, хүний нөөцийн хөгжил, технологи дамжуулах асуудалд чиглүүлж, бодит үр дүнд хүргэх төлөвлөгөө боловсруулан ажиллана. АПЕК-ийн гишүүнчлэлийн ач холбогдол, үр

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

ашгийг харгалзан шинээр гишүүн элсүүлэх асуудлыг үргэлжлүүлэн хянан үзнэ”⁵ гэжээ. Одоогоор энэ талаар гишүүн улс орнууд тодорхой шийдвэрт хүрээгүй, шинээр гишүүн элсүүлэх асуудал бүрхэг хэвээр байна.

АПЕК-г элсэх бэлтгэл ажлын хүрээнд “Танцаарчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө”-г АПЕК-ийн жишгийн дагуу боловсруулсан. Мөн Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (ПЕКК)-ийн гишүүнээр 2008 оны 7-р сард элссэн.

АПЕК-ийн гишүүнчлэлийн шалгуур

АПЕК-г гишүүнээр элсэх, гишүүн бус статустай үйл ажиллагаанд нь оролцоход аливаа улс оронд нээлттэй байдаг. Гэхдээ үйл ажиллагаагаа үр ашигтай явуулах нөхцөл бүрдүүлэхийн тулд гишүүнчлэлээ хязгаарлах үүднээс шинээр гишүүн элсүүлэх шалгуурыг 1997 оны Ванкуверт болсон АПЕК-ийн сайд нарын уулзалтаар дараахь байдлаар тогтоосон.

- Ази, номхон далайн бүс нутагт байрладаг байх,
- АПЕК-ийн гишүүдтэй худалдаа, эдийн засгийн өргөн харилцаатай байх,
- Гадаад худалдаанд нь АПЕК-ийн гишүүдийн эзлэх хувь өндөр байх,
- Зах зээлийн эдийн засгийн системийг эрхэмлэдэг байх,
- АПЕК-ийн зорилго, зарчмыг хүлээн зөвшөөрсөн байх,
- Шинээр гишүүн элсүүлэх эсэхийг нийт гишүүний зөвшилцөлд тулгуурлан шийдвэрлэдэг учраас олон орны дэмжлэгийн авсан байх,
- Гишүүнчлэл нь дэмжигдсэн эдийн засаг АПЕК-ийн үйл ажиллагаанд оролцохын тулд худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын чиглэлээр “Танцаарчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө” гаргасан байх.

Монгол Улсын хувьд АПЕК-ийн гишүүнчлэлийн дээрх шалгууруудыг дараах байдлаар хангаж байна. Үүнд:

5. <https://www.apec.org>

- Монгол Улс газарзүйн хувьд тус бүс нутагт оршдог. Дэлхийн Банкны ангилалаар Монгол Улс Зүүн Ази, номхон далайн бүс нутагт харъяалагддаг.
- Монгол Улсын гадаад худалдааны нийт эрэлтийн 86%, гадаадын хөрөнгө оруулалтын 70 орчим % АПЕК-ийн гишүүн орнуудад ноогддог.⁶
- Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн бөгөөд одоогийн байдлаар олон улсын байгууллагуудаас Монгол Улсыг шилжилтийн үеэ даван туулсан хэмээн тодорхойлдог нь Монгол Улсыг зах зээлийн эдийн засагт бүрэн шилжсэн орон гэдгийн баталгаа юм.
- Монгол Улс АПЕК-ийн зорилго, зарчмыг дэмждэг бөгөөд АПЕК-тай хамтран ажиллах улмаар гишүүнээр элсэх сонирхолтой байгаагаа 1993 оноос хойш удаа дараа илэрхийлсээр байна.

Монгол Улсыг АПЕК-т гишүүнчлэхэд учирч болох саад бэрхшээл

Сүүлийн хоёр шалгуурыг хангахад Монгол Улсын зүгээс нэлээн хүчин чармайлт шаардагдаж байгаа. Уг шалгуурт нийцэхээр Монгол Улс тодорхой системтэй ажлуудыг хийсээр байна. Монгол Улс АПЕК-ийн зорилго, зарчмыг дэмжиж байгаагаа илэрхийлж, АПЕК-тай хамтран ажиллах ингэхдээ эхний ээлжинд түүний ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд оролцох улмаар гишүүнээр элсэх сонирхолтой байгаагаа мэдэгдэж, холбогдох улс орон, олон улсын байгууллагын дэмжлэгийг авах талаар хоёр талын шугамаар болон АПЕК-ийн НБДГ-аар дамжуулан идэвхитэй ажилласаар байна. Үүний нэг том илрэл нь АПЕК-т гишүүнээр элсэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн Ерөнхий сайд П.Жасрайгийн илгээлтийг 1993 онд АПЕК-ийн гүйцэтгэх захирал Ц.Боддед гардуулсан явдал юм. Түүнчлэн 2014 онд анх удаагаа АПЕК-ийн удирдагчдын уулзалтанд урилгаар оролцсон. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын төр засгийн төлөөлөгчид АПЕК-ийн гишүүн орнуудын удирдлагуудтай тус тусын шугамаар уулзахдаа АПЕК-т элсэх, түүний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцох хүсэлтэй байгаагаа

6. <https://www.mfa.mn/>

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

илэрхийлэн, дэмжлэг үзүүлэхийг хүсч ирсэн. 1996 оноос Монгол Улс АПЕК-т гадаад худалдаа дэмжих, эрчим хүч, аялал жуулчлал, тээвэр гэсэн 4 ажлын хэсэгт зочны статустай оролцож эхэлсэн байна.

Мөн худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын чиглэлээр өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулсан. АПЕК-ийн гишүүнд элсэх шалгуурыг бүрэн хангахын төлөө тодорхой ажлуудыг хийж гүйцтгээд байгаа хэдий ч одоог хүртэл гишүүнээр элсээгүй байгаа нь учирч буй саад бэрхшээлүүдтэй холбоотой.

АПЕК-т элсэхэд тулгараад байгаа саад бэрхшээлүүдийг ерөнхийд нь 2 ангилж үзэж болно.

1. Гадаад хүчин зүйл буюу АПЕК-ийн зүгээс гарч ирсэн саад бэрхшээл
2. Дотоод хүчин зүйл буюу Монгол Улсын зүгээс гарч буй саад бэрхшээл

Монгол Улсын хувьд АПЕК-аас үүдэлтэй гол бэрхшээл нь “гишүүнчлэлийн хориг”. АПЕК-ийн хувьд 1997 оны уулзалтаараа ОХУ, Перу, Вьетнамыг гишүүнээр элсүүлж, АПЕК-ийг бэхжүүлэх 10 жилийн хугацаа тогтоож энэ хугацаа дууссаны дараа шинэ гишүүн элсүүлэх асуудлыг авч хэлэлцэхээр тогтсон. Монгол Улсаас гадна Энэтхэг, Пакистан, Макао, Панам, Колумб, Шриланк, Эквадор, Коста Рика, Лаос зэрэг орон АПЕК-т элсэх хүсэлтээ илэрхийлж байгаа. 2007 онд уг гишүүнчлэлийн хориг дуусгавар болох байсан хэдий ч өнөөг хүртэл АПЕК хориггоо цуцлаагүй байгаа нь асуулт дагуулсаар байна.

АПЕК-ийн гишүүнчлэлийн хориг тогтоосон явдал нь үйл ажиллагаагаа бэхжүүлэх зорилготой байсан. Өөрөөр хэлбэл өөрийн өмнө тулгараад байгаа зарим асуудлуудаа эмхлэн шийдвэрлэхийн тулд АПЕК нь гишүүн элсүүлэх асуудлыг 10 жил хойшлуулсан.

АПЕК-т тулгарсан саад бэрхшээлүүд болон гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл:

- *АПЕК-ийн хөгжлийн эрч харьцангуй суларсан.* АПЕК-ийн хөгжлийн эрчийг бууруулсан хүчин зүйлс нь нэгээр тогтохгүй байдаг бөгөөд судлаачид олон талын байр сууринаас ханддаг. АПЕК-ийн эрч буурсан гол шалтгаан нь АПЕК ямар зорилт

дэвшүүлэн ажиллах, тэр зорилтонд хэрхэн хүрэх тухайд гишүүд нь хэт зөрүүтэй байр суурьтай байдагтай холбоотой гэж олон судлаачид үздэг. АПЕК-ийн хөгжиж буй гишүүд эдийн засаг техникийн хамтын ажиллагаа нь худалдууны либералчлалын салшгүй нэг хээг байх ёстой гэж үздэг. Эдийн засаг техникийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжиж буй орнуудын институциуныг бэхжүүлэх, бодлого боловсруулах механизмыг сайжруулах нь хөгжиж буй орнууд худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах нөхцөл бүрдэнэ хэмээн тэдгээр орнууд үздэг талтай. Харин АНУ тэргүүтэй хөгжингүй орнууд АДЕК-ийг либералчлалын цонхоор харж ирсэн.

- *Гишүүнчлэлээ хэт өргөжүүлсэн.* Гишүүдийнхээ хэт зөрүүтэй байдлыг үл харгалзан худалдааны либералчлалын чиглэлээр туулахад хэцүү сорилт тавьсан нь тийм ч зүйтэй зүйл биш байсан.
- *АПЕК-ийн хэлэлцэх асуудлууд хэт олон болсон.* Энэ нь АПЕК-ийн хөгжилд сөргөөр нөлөөлсөн гэж зарим судлаачид үздэг. АПЕК-ийн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэхтэй холбоотой асуудлаас эхлээд авто замын ослын талаарх нэгдсэн статистик мэдээлэлтэй болох, эмэгтэй биенес эрхлэгчдийг дэмжих хүртэлх маш өргөн хүрээний асуудлуудыг хэлэлцдэг. Тухайлбал зөвхөн 2004 онд 121 шинэ санаачлага, төсөл хэрэгжиж эхэлсэн. АПЕК-ийн НБДНГазар жилд сайд нарын түвшний 14 уулзалт, бусад түвшний албан тушаалтнуудад зориулсан 54 уулзалт зохиодог байх жишээтэй. Худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах асуудалд гол ахиц гарахгүй байснаар өөр бусад салбарт санал санаачлага гарч дэмжигдэхэд хялбар болсон бөгөөд дээд хэмжээний уулзалтууд олон нийтийн анхаарлын төвд байдаг тул олон нийт, хэвлэлийнхэнд зориулсан шинэ санал санаачлага дэвшүүлэх явдал их тохиолдох болсоноос шалтгаалан АПЕК-ийн хүрээн дэх санаачлагуудын тоо эрс нэмэгдсэн байх магадлалтай.
- *Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд улс хоорондын стратегийн зөрчил, газар нутгийн маргаан бүрэн арилаагүй байна.* Солонгосын хойгийн асуудал нь аюулгүй байдлын өөр хүчин зүйлсийг, тухайлбал, хүн төрөлхтний аюулгүй байдал, үй

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

олноор хөнөөх зэвсгийн тархалт, их гүрнүүдийн геополитикийн зөрчил зэрэг бусад хүрээг хамарч байгаа бол, Тайваний асуудлыг улс хоорондын гэхээсээ салан тусгаарлах үзэлтэй холбож БНХАУ-ын дотоод аюулгүй байдлын хүрээнд тайлбарлах ёстой юм. Харин газар нутгийн гол маргаанууд нь ОХУ-Япон, Энэтхэг-Пакистан, Филиппин-Индонез, Папуа Шинэ Гвиней-Соломон арлуудын хооронд төдийгүй, Өмнөд Хятадын Тэнгис дэх маргаан хүртэл анхаарал татсан асуудлууд болж байна.

- *Улс орнуудын бүрэн бүтэн байдал нь алдагдаж болзошгүй орнуудын асуудал.* Үүнд: Умард Солонгос, Балба, Мьянмарыг дурдаж болно. Тухайлбал: Балбад нэг талаас ардчиллын элементүүдийг хумигдуулж, өөрийн гарт хязгааргүй эрх мэдлийг төвлөрүүлээд байгаа хаан, нөгөө талаас хэт даврагя хэнээт үзлийг баримтлагч террорист бүлэглэлийн үйл ажиллагааны дунд хүний эрх ноцтой зөрчигдөж байна. Мөн Умард Солонгос, Мьянмар улсууд өөрийн гэсэн хөгжлийн замыг сонгохдоо гадаад ертөнцөөс тусгаарлагдах, итгэлцлийн үйл явцаас гадна хоцрохоор шийдсэн нь бүс нутаг дахь хүчнүүдийн зохицолд саад болж байх боломжтой.
- *Улс төрийн харилцан адилгүй байдал.* АНД-н бүс нутгийн хэмжээнд ерөнхийлөгчийн, парламентын, олон намт ардчилсан, нэг намын удирдлага бүхий, хэмжээт эрхт хаант, цэргийн дэглэмт, үндсэн хуульт хаант, хэмжээт эрхт хаант, шашин төрийг хослон баригч хаант зэрэг засаглалын олон хэлбэр бүхий улсууд зэрэгцэн оршиж байдаг. Иймд нэг улсын улс төрийн тогтолцоог нөгөөд нэвчүүлэх үзэл санаа Азийн судлаачдын дунд төдийлөн хүлээн зөвшөөрөгдөхгүй байгааг дурдах хэрэгтэй.⁷
- *Үй олноор хөнөөх зэвсгийн тархалт.* Энэ бүс нутгийн төдийгүй дэлхий дахинд тулгарч буй нийтлэг асуудал бол үй олноор хөнөөх зэвсгийн тархалт. Ойрын үед энэ бүс нутагт нэн тулгамдсан асуудал бол нөгөө хуучны сэдэв болох Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудал юм.

7. <http://open.parliament.mn/content/1077.htm>

**Монгол Улсын АПЕК-т гишүүнчлэхэд гарах эерэг ба сөрөг тал
Эерэг талууд:**

- Худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн хөнгөлөлт, эдийн засаг болон техникийн хамтын ажиллагаа эрчимжих боломжтой.
- Эдийн засгийн хувьд нэг улсаас хэт хараат байх нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй. АПЕК-ийн хүрээнд улс орнуудтай харилцаагаа сайжруулж улмаар АПЕК-т элссэнээр гишүүн эдийн засгуудтай харилцаа, итгэлцлээ сайжруулж олон талт эдийн засгийн бодлого явуулсанаар нэг улсаас хэт хараат байх эрсдэлээс ангижирах боломжтой.
- Харьцангуй тэнцвэртэй гадаад худалдааны нөхцөл бий болно.
- АПЕК гэх эдийн засгийн интеграцид орсоор олон тулгуурт гадаад бодлогын зарчмын хүрээнд хоёр талт хамтын ажиллагааг эрчимжүүлж, худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн салбарт хамтын ажиллагаагаа сайжруулах боломж нээгдэнэ.
- Чөлөөт худалдааны бүсэд нэгдэх боломжтой болно.
- Далайд гарцтай болох. Чөлөөт худалдааны хэлэцээрээр дамжуулан өөрсдийн түүхий эдээ усан замаар хөнгөлөлттэй тариф, татвартайгаар тээвэрлэх боломж бий болох ыгөөд дотоодын аж үйлдвэрлэл хөгжих боломжтой. Цаашлаад ажлын байр бий болох боломж үүснэ.
- Олон улсын хөрөнгө оруулалт болон техник технологийн дэвшилт нэвтрэх. Шинэ техник технологээр дамжуулан өөрийн улсын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх боломжтой.
- Хүн капиталд хөрөнгө оруулалт хийх. АПЕК-ийн ихэнх гишүүн орнууд нь чадварлаг боловсон хүчин бэлтгэгдээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Тиймээс АПЕК-ийн гишүүн улс орнуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлснээр боловсон хүчин солилцон бэлтгэх, туршлага солилцох боломж нээгдэнэ.
- АПЕК-ийн яриа хэлэлцээрүүдэд нэгдэн, туршлага солилцох, өөрт ашиг олох боломжтой.
- Монгол Улсын олон улс дахь нэр хүнд өсөх. АПЕК-ийн ажлын хэсэгт гишүүний статустай оролцсоноор хоёр болон олон талын

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

шугамаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд оролцож ашиг хүртэх боломж нэмэгдэж цаашлаад олон улс дахь Монгол Улсын нэр хүнд өсөх боломжтой.

- Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжтой. 2014 оны АПЕК-ийн удирдагчдын дээд хэмжээний уулзалтаар 2030 он гэхэд гишүүн орнуудынхаа сэргээгдэх эрчим хүчний хэмжээн 2 дахин нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн ба хэрэв Монгол Улс АПЕК-т гишүүнээр элсвэл уг зорилтыг хамтран хэрэгжүүлэх боломжтой болно.
- АПЕК-т нэгдсэнээр эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн хүний хөгжлийн индекс өсөх боломжтой. 8 2010 оны байдлаар НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн Хүний Хөгжлийн Индексээс доогуур орлоготой АПЕК-ийн гишүүн эдийн засгуудын үзүүлэлт ойролцоогоор 18%-иар өссөн гэсэн судалгаа гарчээ.
- Эдийн засгийн эрчимтэй өсөлтийн үр ашгаар ядуурлыг бууруулах хөтөлбөр, санаачлага амжилттай хийгээд эрчимтэй хэрэгжих шаарлага бий болно. Зүүн Азийн АПЕК-ийн гишүүн орнууд 10 жилийн хугацаанд ядуулыг бараг 3 дахин багасгасан судалгаа бий бөгөөд энэ нь нийт 165 сая хүний амжиргааны түвшин сайжирсан гэсэн үг юм. Монгол Улс АПЕК-ийн гишүүн болсоноор өөрийн гишүүний үүргээ ухамсарлан эдийн засгаа сайжруулсанаар ядуурлын эсрэг төсөлт хөтөлбөрүүдийг санаачлан амжилттай хэрэгжүүлэх боломжтой юм.

8. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс дэлхийн улс орнуудын “Хүний хөгжлийн индекс”-ийг (Human Development Index) жил бүр тооцон гаргадаг. 2014 онд гарагасан шинэ индексээр дэлхийн хамгийн хөгжилтэй орноор Норвеги шалгарч, Австрали, Швейцарь, Нидерланд, Америк улсууд удаалсан байна. Энэ судалгаанд нийт 187 орон хамрагдсанаас Монгол Улс 103-р байрт, Хүний хөгжлийн түвшин дундаж орны тоонд багтжээ. ОХУ 57, Хятад 91 дүгээр байр эзэлж, Хүний хөгжлийн түвшин өндөр орны жагсаалтанд оржээ. ХХИ гэдэг нь тухайн улс орны хүний хөгжлийн түвшинг харуулдаг бөгөөд энэ нь амьдралын түвшин, чанартай салшгүй холбоотой. ХХИ-ийг

1. Хүн амын эрүүл мэнд, урт наслалт
2. Боловсрол эзэмших боломж, насанд хүрсэн хүн амын бичиг үсэг тайлагдсан байдал
3. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ гэсэн гурван үзүүлэлтээр хэмжин гаргадаг.

Үзүүлэлт тус бүрт 0-1 оноо өгч, улс орнуудыг

1. Маш өндөр хүний хөгжилтэй орон
2. Хүний хөгжлийн түвшин өндөр орон
3. Хүний хөгжлийн түвшин дундаж орон
4. Хүний хөгжлийн түвшин бага орон гэж дөрөв ангилдаг.

- Шинэ ажлын байр бий болох. 2010 оны судалгаагаар АПЕК-ийн гишүүн эдийн засгуудад 195 сая ажлын байр шинээр бий болсон байна. Энэ нь мөн эдийн засгийн нээлттэй байдал, техник технологийн дэвшил, хөрөнгө оруулалттай шууд холбоотой.
- Хүүхдийн эндэгдэл буурч, хүн амын дундаж наслалт өсөх, эрүүл ахуй үйлчилгээ, ундны усны хүртээмжтэй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцлөөр олон нийтийг хангаснаар дээрх асуудал шийдэгдэх боломжтой. Энэ нь мөн эдийн засгийн өссөлттэй шууд холбоотой.

Сөрөг талууд:

- Монгол Улсын дотоодын бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадвар муу учраас эдийн засгийн давалгаанд дампуурах аюултай.
- Хоёр талын хамтарсан гэрээний хэрэгжилт амжилтгүй байвал Монгол Улсын олон улсын нэр хүндэд сөрөг нөлөөтэй ба улс орнуудтай харилцах харилцаанд итгэлцэл үгүй болох аюултай.
- Гадаадын хөрөнгө оруулалтын хууль нэг мөр болоогүй тул гадаад компани, түншлэгчдийн хувьд эргэлзээ үүсэх эсвэл бүр хуулийн эмх замбараагүйг ашиглах боломж үүсч Монгол Улсад ашиггүй цаад талдаа ашигтай тохиролцоо бий болох магадлалтай.
- Хуулийн цоорхойг ашиглан их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт орсноор Монгол Улс дахь дотоодын хэвшлүүдийн үйл ажиллагаа гадаадын хөрөнгө оруулагчдаас хэт хараат болох аюултай.
- Олон нийтийн дунд мэдээлэл дутмаг явдлаас болж олон нийт зарим тохиолдолд эсэргүүцэл үзүүлэх, гэнэтийн цочролд орох, олон нийтийн дунд ташаа ойлголт бий болох магадлалтай.

АПЕК-ийн нэг том зорилт бол тус бүс нутгийн хөгжингүй орнуудыг 2010 он, хөгжиж буй орнуудыг 2020 он гэхэд чөлөөт болон нээлттэй худалдаа, хөрөнгө оруулалтын тогтолцоонд тус тус шилжүүлэх нөхцөл бүрдүүлэх явдал юм.

АПЕК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС

ДУГНЭЛТ

Монгол Улс АПЕК-ийн гишүүнчлэлийн шалгуурыг хангаж байгаа хэдий ч шинээр гишүүн элсүүлэх асуудлыг хэлэлцэхдээ энэ шалгуурыг яг таг дагана гэсэн баталгаа байхгүй юм. Хүсэлт гаргасан орны улс төр, эдийн засгийн хүчин чадал, бүс нутаг дахь нэр нөлөө албан ёсны шалгуураас ч илүү жинтэй байх магадлалтай.

Монгол Улс АПЕК-д элсэхэд дараахь 3 саад бэрхшээл байна гэж үзэж байна. Үүнд:

1. АПЕК-ийн гишүүдийн олонхийн саналыг авч чадахгүй байгаа явдал юм. Одоогийн байдлаар АПЕК-ийн гишүүн элсүүлэх шалгуурын хамгийн чухал нь “гишүүдийн зөвшилцлөөр шийдвэр гаргах” болоод байгаа билээ. Гэтэл манай улс эдийн засгийн чадавхи сул тул бүс нутгийн хөгжилд нөлөөлөх, АПЕК-ийн үйл явцад хувь нэмэр оруулах боломж хязгаарлагдмал гэж зарим АПЕК-ийн гишүүд үзэж байгаагаас Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал дэмжигдэхгүй байгаа бөгөөд Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал гишүүдийн зөвшилцөлд хүрч чадахгүй байгаа юм.
2. Монгол Улс АПЕК-т гишүүнээр элсэхээр хийж байсан үйл ажиллагааны эрч буурсан явдал юм. Энэ нь АПЕК-ийн 10 жилийн хоригтой холбоотой байж болох юм. АПЕК-ийн ажлын хэсгүүд, ПЕКК-ийн үйл ажиллагаанд оролцон, худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын чиглэлээр ганцаарчилсан ажлын төлөвлөгөөг гаргасан нь АПЕК-т элсэхийн тулд зайлшгүй хийх ёстой зүйл биш харин АПЕК-т элсэх, тус үйл явцад хувь нэмрээ оруулах чиглэлээр эрмэлзэлтэй байгаагаар илэрхийлэх зорилготой арга хэмжээ байсан хэдий ч сүүлийн жилүүдэд эрч нь буураад байна.
3. Монгол Улсад АПЕК-ийн талаар судалгааны цогц мэдээлэл боловсруулдаг, олон нийтэд хүргэдэг судалгааны нэгдсэн институци байхгүй явдал юм. Үүнтэй холбоотойгоор АПЕК-ийн тухай мэдлэг, мэдээлэл олон нийтэд хангалтгүй хүрдэг ба АПЕК нь Монгол Улсад бүрэн танигдсан хамтын ажиллагааны механизм болж амжаагүй байна.